



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
SCHOOL OF ARTS AND SCIENCES
DEPARTMENT OF GEOGRAPHY

Geographical Issues

Газарзүйн Асуудлууд

Volume 25 (02)

ISSN: 2312-8534

2025

Ulaanbaatar

Study on spatial and temporal changes in tourism destinations: A case study of Inner Mongolia, China

Enkhjargal Dalaibaatar¹, Suyali¹, Oyunchimeg Luvsandavaajav¹, Bayarmanlai Norjin¹, Ariunsanaa Narantuya¹, Gantuya Narantuya^{1*}

¹Department of Geography, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar 210646, Mongolia

*Corresponding author: n.gantuya@num.edu.mn

Received: 2025.04.04

Revised: 2025.04.30

Accepted: 2025.05.02

Abstract

In 2000, China initiated a quality assessment program for tourist destinations, classifying them into grades ranging from 1A to 5A. This classification is based on various criteria, including the location, environment, infrastructure development, quality and standards of services offered to tourists, as well as the significance of historical and cultural resources. According to this quality assessment, 3A-level tourist destinations are usually places of local or regional importance with average services and infrastructure. This study examined the spatial distribution and differentiation of 3A level tourist destinations in Inner Mongolia, utilizing a spatial database from 2004 to 2022. The spatial distribution of 3A level tourist destinations in Inner Mongolia shows a significant evolution over time. In 2004, these destinations were relatively few and primarily concentrated in cities such as Hulunbuir, Xilingol province, and Ulanqab. However, as the tourism sector rapidly developed, the number of 3A level destinations gradually increased and expanded into urban areas like Hohhot and Baotou, as well as the surrounding regions. This indicates a trend towards diversified spatial development in tourist destinations. The study confirmed that from 2004 to 2022, the spatial distribution of 3A-level tourist destinations in the Inner Mongolia was primarily influenced by a combination of natural, historical, and cultural tourism resources, as well as transportation networks and development along key economic corridors.

Keywords: 3A level tourist destination, spatial distribution, LISA clustering, Inner Mongolia

Аялал жуулчлалын зорих газрын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн шинжилгээ (БНХАУ-ын ӨМӨЗО-ы жишээн дээр)

©Далайбаатар Энхжаргал¹, Suyali¹, Лувсандаваажав Оюунчимэг¹, Норжин Баярманлай¹, Нарантуяа Ариунсанаа¹, Нарантуяа Гантуяа^{1*}

¹Газарзүйн тэнхим, Шинжлэх Ухааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар 210646, Монгол Улс

*Харилцагч зохиогч: n.gantuya@num.edu.mn

Хүлээн авсан: 2024.04.04

Засварласан: 2025.04.30

Зөвшөөрөгдсөн: 2025.05.02

Хураангуй

БНХАУ 2000 оноос аялал жуулчлалын зорих газруудад чанарын үнэлгээ хийж эхэлсэн бөгөөд тухайн газрын байриил, хүрээлэн буй орчин, дэд бүтцийн хөгжил, жуулчдад үзүүлж буй үйлчилгээний чанар, стандарт, байгаль, түүх, соёлын нөөцийн ач холбогдол зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр 1А-5А хүртэлх зэрэглэлээр ангилдаг. Уг чанарын үнэлгээний дагуу 3А зэрэглэлийн аялал жуулчлалын газруудад ихэвчлэн дунд зэргийн үйлчилгээ, дэд бүтэц бүхий, орон нутгийн эсвэл бүс нутгийн ач холбогдол бүхий газрууд багтдаг. Энэхүү судалгаанд Өвөр Монголын аялал жуулчлалын 3А зэрэглэлийн 115 зорих газрын 2004-2022 оны орон зайн өгөгдлийн санд үндэслэн орон зайн тархалт, тэдгээрийн ялгаатай байдлыг тодорхойлсон болно. Өвөр Монголын эдгээр газруудын орон зайн тархалтын үйл явцаас харахад 2004 онд 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрын тоо харьцангуй цөөн Хөлөнбуйр хот, Шилийн гол аймаг, Улаанхад хотуудад төвлөрч байсан бол аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжихийн хэрээр 3А зэрэглэлийн аялал жуулчлалын газрын тоо аажмаар нэмэгдэж Хөх хот, Бугат хот зэрэг хот суурин болон ойр орчмын бүс нутгуудад өргөжин орон зайн тархалтын хувьд ч төрөлжсөн хөгжиж байна. 2004-2022 онд ӨМӨЗО-ы аялал жуулчлалын зорих газруудын орон зайн тархалтад байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын нөөцөөс гадна зам тээврийн сүлжээ, төв тэнхлэг дагуух хөгжил голлох үүргийг гүйцэтгэсэн болох нь судалгаагаар тогтоогдов.

Түлхүүр үгс: Аялал жуулчлалын зорих газрууд; орон зайн тархалт; LISA бөөгнөрөл, Өвөр Монгол

©Зохиогчийн оруулсан хувь нэмэр: Д.Энхжаргал, Н.Гантуяа, Л.Оюунчимэг: Онолын үндэслэл, аргазүй боловсруулалт, өгөгдөл боловсруулалт, үндсэн бичвэр, үр дүнгийн хяналт, Suyali, Н.Баярманлай, Н.Ариунсанаа: өгөгдөл цуглуулалт, боловсруулалт, үр дүнгийн хяналт.

Оршил

Аялал жуулчлалын салбар хурдацтай хөгжихийн хэрээр дэлхий дахинаа тэргүүлэх салбарын нэг болон байр сууриа эзэлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 10.9 их наяд ам.долларын орлого олж дэлхийн эдийн засгийн 10 хувийг бүрдүүлж байна (WTTC, 2024). Түүнчлэн аялал жуулчлалын салбар хөгжингүй төдийгүй дундаж орлоготой орнуудын нийгэм, эдийн засгийн чухал хөдөлгөгч хүч болжээ (Hossain et al., 2024). Гэвч аялал жуулчлал нь улс төр, эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчин зэрэг гадаад орчны хүчин зүйлээс маш их хамааралтай салбар учраас жуулчдын урсгал чиглэлээс хамаарч аялал жуулчлалын зорих газруудын зах зээл дээрх өрсөлдөөн байнга өөрчлөгдөж байдаг (Lyu et al., 2023). Энэ утгаараа улс орнууд аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэхийн тулд өөрийн орны жуулчны зорих газрын өрсөлдөх чадварыг тодорхойлох, эсвэл зэрэглэх, төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол улс үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлэх (МУ-ын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2024) үүднээс 7 бүсийг ялган бүс тус бүрийг хөгжүүлэх үүднээс бодлогын бичиг баримтыг боловсруулах, бүсийн чуулган уулзалтуудыг зохион байгуулж байна. Монгол улсад гадаад, дотоодын жуулчдыг сонирхон очдог аялал жуулчлалын зорих газруудын талаарх судалгаа харьцангуй бага хийгдсэн байдаг. Харин судлаач У.Хишигдалай Монгол орны зорих газруудыг эрэмбэлэх ажлыг анх 2015 онд хийн нийт 11 аялал жуулчлалын зорих газрыг байгаль, түүх, соёлын үзмэр, эвент арга хэмжээ, зорих газарт хүрэх боломж, жуулчдад үзүүлэх үйлчилгээ, санал болгож буй үнэ, жуулчдын аюулгүй байдал, хүрээлэн буй орчны чанар, уур амьсгал зэрэг 6 бүлэг хүчин зүйлээр эрэмбэлсэн байдаг (Хишигдалай, 2015).

БНХАУ-ын Засгийн Газраас аялал жуулчлалын бүс нутгуудыг тухайн орон нутгийн байгалийн үзэсгэлэн, түүх, соёлын өв, жуулчдад үзүүлэх үйлчилгээний стандартыг үнэлж тогтоон 1А-5А зэрэглэлээр ангилан хуваадаг (GB/T 17775-2003). Энэхүү зэрэглэлийн ангилалаар аялал жуулчлалын зорих газрыг тээвэр (14%), үзвэр үйлчилгээ (21%), жуулчны аюулгүй байдал (8%), эрүүл мэнд (14%), шуудан, харилцаа холбооны үйлчилгээ (3%), жуулчинд зориулсан худалдаа (5%), менежментийн тогтолцоо (19.5%), нөөц болон байгаль орчныг хамгаалах систем (15.5%) гэсэн найман бүлэг хүчин зүйлээр үнэлдэг байна (GB/T 17775-1999).

ӨМӨЗО нь БНХАУ-ын 5 томоохон аялал жуулчлалын зорих газрын нэг бөгөөд 2022 оны байдлаар тус улсад байгалийн үзмэр, соёлын сонирхол татах үзмэрүүдтэй 3А зэрэглэлийн аялал жуулчлалын 115 зорих газар (China National Tourism Administration, 2022) бүртгэгдсэнээс Хөлөн буйрын тал нутгийн үзмэрит газар, Улаанцавын Калажүн үндэсний геопарк, Ордос хотын Шаншаван аялал жуулчлалын бүсүүд жилээс жилд жуулчдын сонирхон очдог газар болон хөгжиж байна. 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газар нь байгаль, түүх, соёлын баялаг нөөцтэй, жуулчдын эрэлт хэрэгцээг хангахуйц стандарт үйлчилгээний орчин нөхцөл бүхий тухайн орон нутгийн нийгэм, эдийн засагт тодорхой хэмжээний үр өгөөж үзүүлдэг (Jinghu, 2014), Хятад улсын Үндэсний аялал жуулчлалын газрын чанарын үнэлгээний хорооноос зөвшөөрөл олгосон мужийн хэмжээний аялал жуулчлалын бүс нутаг юм. Эдийн засгийн даяаршил, дотоод гадаадын орчны хурдацтай өөрчлөлтийг дагаад 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд хөгжлийн шинэ сорилтуудтай тулгарч байна. Бүс нутаг бүрт байгаль газарзүйн онцлог, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин, түүх соёл, нийгмийн дэд бүтцийн нөхцөл, үйлдвэрлэлийн бүтэц зэрэг олон талын ялгаатай байдлаас шалтгаалан 3А зэрэглэлийн аялал жуулчлалын газруудын орон зайн зохион байгуулалт харилцан адилгүй байна. Эдгээр бүс нутгууд орон зайн хувьд тархан хөгжихөд байгаль, нийгмийн олон хүчин зүйлс нөлөөлж буй талаар хэд хэдэн судалгаанууд хийгдсэн ч

тухайн газрын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн онцлог, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг нэгдсэн байдлаар авч үзсэн судалгаа хараахан хийгдээгүй байна.

Судлаач Лю (2017)-ийн “Цэг-тэнхлэг систем”-ийн болон орон зайн бүтцийн онолд тулгуурлан Ухань-Гуанжоугийн HSR (high speed transportation) шугам дагасан бүс нутгийн аялал жуулчлалын орон зайд өндөр хурдны зам тээврийн үзүүлэх нөлөөллийг судлан гаргасан байдаг. Үүний үр дүнд Ухань-Гуанжоугийн HSR шугам дагасан аялал жуулчлалын эдийн засгийн бүсийг а) аялал жуулчлалын эдийн засгийн цөм бүс, б) аялал жуулчлалын эдийн засгийн дэд бүс, в) эдийн засгийн хязгаарлалтын бүс гэж хуваах санал дэвшүүлсэн нь бүс нутгийн аялал жуулчлалын эдийн засгийг эрүүл, хурдацтай хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлсэн (Lui, 2017).

Зао (2021) үзсэнээр сонирхол татах цэг (Point of Interest)-ийн өгөгдөл болон орон зайн мэдээллийн дүрслэлийн технологи ашиглан аялал жуулчлал, амралт зугаалгын бүс болон түүний дэд бүсүүдийн орон зайн бүтцийн онцлогийн талаар судалжээ. Түүний судалгаагаар аялал жуулчлал, амралт зугаалгын бүс болон түүний дэд бүсүүдийн хамгийн ойрын интерполяци 1-ээс бага байсан нь Бээжин дэх аялал жуулчлал, амралт зугаалгын бүс болон түүний дэд бүсүүд орон зайн хувьд бөөгнөрөл үүссэнийг илрүүлсэн байна (Zhao, 2021).

Аялал жуулчлалын зорих газрын зэрэглэлийн ангилал болон орон зайн бүтцийнх нь хувьсалд тухайн бүс нутгийн дэд бүтэц, жуулчдад зориулсан үйлчилгээний хүртээмж, зах зээлийн багтаамж, хот болон суурин газрын эдийн засгийн хөгжлийн түвшин хүчтэй нөлөө (He et al., 2021) үзүүлдэг байхад тухайн газруудын газарзүйн байрлал, газрын хэлбэр, усны зүйн тархалт зэрэг байгалийн хүчин зүйлс нь харьцангуй тогтвортой нөлөө үзүүлдэг (Qui et al., 2021). Үүнээс үзэхэд байгалийн болон нийгмийн хүчин зүйлүүд нь аялал жуулчлалын зорих газрын зэрэглэл үүсэх нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээр газруудын орон зайн бүтцийн хувьслыг дэмждэг болох нь тодорхойлогдож байна. Энэ судалгаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ы аялал жуулчлалын зорих газрын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн шинжилгээг хийх зорилгыг дэвшүүлэв.

Судалгааны талбай

Аялал жуулчлалын нөөц бол тухайн бүс нутгийг аялал жуулчлалын орон зайн өрсөлдөөнд дэмжлэг үзүүлдэг чухал шалгуур юм (Tongyan, 2022). Тодорхой бүс нутгийн аялал жуулчлалын хөгжил нь нөөцийн ашиглалтын түвшингээс хамаардаг бөгөөд түүний орон зайн бүтцийг судлах нь зорих газрыг хөгжүүлэх, ашиглахад чухал ач холбогдолтой.

Өвөр Монголын аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн судалгаа нь голчлон аялал жуулчлалын нөөцийн ангилалаас хамаарсан аялал жуулчлалын нөөцийн бүсчлэлд тулгуурлан хийгддэг. Өвөр Монголын аялал жуулчлалын А зэрэглэлийн зорих газрууд нь таван үндсэн бүсэд хуваагддаг. Үүнд:

- Хот суурин газрын тойргийн аялал жуулчлалын бүс (Хөх хот, Бугат хот, Ордос хот, Улаанцав хот);
- Ой, тал хээрийн аялал жуулчлалын бүс (Хөлөнбуйр хот, Шилийн гол аймаг, Хянган аймаг);
- Элсэн цөлийн, соёлын аялал жуулчлалын бүс (Баяннуур хот, Алшаа аймаг, Үхай хот);
- Балгас ба түүх дурсгалын аялал жуулчлалын бүс (Чифэн хот, Тунляо хот).
- Туурь, дурсгалт газруудын аялал жуулчлалын бүс (Улаанхад хот, Тунляо хот).

Олон улсад судлаачид аялал жуулчлалын зорих газруудын судалгааг эхэн үедээ голчлон чанарын судалгааны аргаар хийж байсан бөгөөд судалгааны онол, арга зүй боловсронгуй болохын хэрээр орон зайн бүтцийн тоон судалгааг түлхүү хийж ирсэн. Харин Хятадын судлаачид Өвөр Монголын А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн судалгаанд төдийлөн анхаарал хандуулаагүй, ихэвчлэн статистик талаас нь судалж аялал жуулчлалын нөөцийн ангилал, бүсчлэлд голлон анхаарч байв. Хэдийгээр Хятад улсын бусад аймаг, мужуудын А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн талаар холбогдох судалгаанууд хийгдсэн боловч цаг хугацаа, орон зайг хослуулах байдлаар Өвөр Монголын аялал жуулчлалын газрын орон

зайн бүтэц, хувьслын шинж чанарт динамик дүн шинжилгээ хийх, ялангуяа аялал жуулчлалын зорих газруудын өөрчлөлтийн зүй тогтлын талаарх судалгаа дутагдалтай хэвээр байна. Иймээс аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн тогтолцоог цаг хугацааны өөрчлөлттэй уялдуулах үүднээс ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн зорих газруудыг судалгааны талбай болгон дүн шинжилгээ хийв.


Судалгааны материал, аргазүй

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах аргуудыг ашигласан.

1. Хоёрдогч эх сурвалжийн шинжилгээ

Судалгааны хүрээнд дараах мэдээ, материалуудыг цуглуулан боловсруулалт хийв. Үүнд:

- Хятад улсын Аялал жуулчлалын газар (China National Tourism Administration), ӨМӨЗО-ы Аялал жуулчлалын хөгжлийн хороо болон аймаг, хотуудын холбогдох аялал жуулчлалын газрын вэб хуудаснаас А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын жагсаалт, байгалийн үзэсгэлэнт газрын нэр, газарзүйн байршил, батлагдсан он, нэр өөрчлөгдсөн эсэх, зэрэглэлийн өөрчлөлт зэргийг нарийвчлан шалгаж судалгааны ажлын өгөгдлийг үүсгэсэн. Байгалийн үзэмжит газар болон нийгэм эдийн засгийн индексийн мэдээ, Өвөр Монголын 2004-2022 оны статистикийн эмхэтгэл, Үндэсний эдийн засаг нийгмийн хөгжлийн статистикийн эмхэтгэлээр, 2022 онд ӨМӨЗО-д 3А зэрэглэлийн нийт 115 аялал жуулчлалын зорих газар байгааг гаргасан.
- Өвөр Монголын өндрийн тоон загвар (DEM)-ын мэдээг гео орон зайн өгөгдөл, “The Nature Conservancy (TNC)” байгууллагын <https://www.nature.org/en-us/about-us/where-we-work/united-states/> цахим хуудаснаас авсан GIMMS NDVI-ийн мэдээлэл, ӨМӨЗО-ы 1:1 000 000 масштабын ургамлын тоон зураг, авто зам, гол мөрний сүлжээний тоон өгөгдөлд тулгуурлан боловсруулалт хийв.
- 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудыг цэгийн элементүүд болгон хийсвэрлэж, “Google Earth Pro” болон “Baidu” газрын зургийн координат сонгох хэрэгслийг ашиглан 3А зэрэглэлийн 115 аялал жуулчлалын газруудын орон зай, газарзүйн координатыг гарган байршуулж “Excel” програмыг үндсэн мэдээллийн сан болгон ашиглав. Сүүлийн алхам нь “ArcGIS10.2” программын тусламжтайгаар Өвөр Монголын вектор газрын зургийг оруулж аялал жуулчлалын 3А зэрэглэлийн газруудын орон зайн тархалтын зургийг дараах байдлаар гаргасан (Зураг 1).



Зураг 1. Өвөр Монголын аялал жуулчлалын зорих газруудын тархалт

2. Харьцуулсан шинжилгээний арга

Хоёр ба түүнээс дээш тооны өгөгдлийг харьцуулан шинжлэх замаар тухайн салбарын түүхэн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох боломжтой. Иймээс хоёр гол хүчин зүйл болох орон зай, цаг хугацааны хувьд ялгаатай бүтээл, эх материалын харьцуулалтыг хийж бусад Хятад улсын А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын хувьд орон зай, цаг хугацааны хувьд хэрхэн хувьсан өөрчлөгдөж, судалгааны хөгжлийн үе шатуудад ямар хувьслын шинж чанар, ахиц дэвшил гарсан болохыг тодорхой өгөгдөл, баримт нотолгоонд үндэслэн харьцуулж дүгнэлээ.

3. Чанарын болон тоон шинжилгээний хосолсон арга

ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудад хамаарах нөөцийн мономерын төрлүүдэд дүн шинжилгээ хийж, 2004-2022 онд 3А зэрэглэлийн аялал жуулчлалын газруудын тоо, түвшний өөрчлөлтийг тодорхойлсон. Хувьсах коэффициент буюу эдийн засгийн тооцооны холбогдох загваруудыг ашиглан Өвөр Монголын аялал жуулчлалын А зэрэглэлийн зорих газруудын тархалтын ялгааг тоон байдлаар шинжлэн, улмаар үр дүнг дүрслэн гаргасан.

4. Орон зайн шинжилгээний арга

ArcGIS10.2 программын тусламжтайгаар Өвөр Монголын вектор газрын зургийг оруулан аялал жуулчлалын 3А зэрэглэлийн зорих газруудын орон зайн тархалтын зургийг гаргав. Улмаар интерполяци, орон зайн автокорреляци, стандарт эллипсийн ялгаа зэрэг олон төрлийн газарзүйн тооцооллын загваруудыг ашиглан цаг хугацааны зангилаа бүрт Өвөр Монголын 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тархалт, хүндийн төвийн шилжилтийн зүй тогтол, орон зайн бөөгнөрөл зэргийг тодорхойлсон.

5. Агуулгын шинжилгээ

Энэхүү судалгаанд 2004-2022 он хүртэлх Өвөр Монголын 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тоонд тулгуурлан, 2004, 2010, 2016, 2022 онуудын өгөгдлийг сонгон авч боловсруулалт хийсэн. Үүнд:

- ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрын мономер төрлийн ангиллыг гаргав.
- Зорих газруудын цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн онцлогийг тодруулахдаа
 - 3А зэрэглэлийн газруудын тоо болон тэдгээрийн дотоод түвшний өөрчлөлтөд дүн шинжилгээ хийлээ.
 - ӨМӨЗО-ы бүс нутгийг бүхэлд нь Зүүн Монгол, Төв Монгол, Баруун Монгол гэж хуваан, гурван том бүс нутгийн аялал жуулчлалын зорих газруудын тархалтын ялгаа, тэнцвэрт байдлыг холбогдох эдийн засгийн тооцооны загвараар дүн шинжилгээ хийсэн болно. 2004, 2010, 2016, 2022 онуудын 3А зэрэглэлийн бүсийг сонгон авч орон зайн тархалтын нөхцөл байдлыг хэмжих, холбогдох онолд тулгуурлан түүний өөрчлөлтийн хэлбэр, механизмд дүн шинжилгээ хийлээ.
- ӨМӨЗО-ны 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэв. Байгалийн болон нийгмийн хүчин зүйлс гэсэн 2 нөлөөлөл байх ба байгалийн хүчин зүйлст газар зүйн байршил, ус, ургамал, харин нийгмийн буюу хүний хүчин зүйлст бодлогын дэмжлэг, нийгмийн цогц хөгжлийн түвшин, авто замын нөхцөл байдлыг хамруулан тооцсон болно.


Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Аялал жуулчлалын зорих газруудын бүсчлэл: БНХАУ аялал жуулчлалын зорих газруудыг 5 шатлал бүхий зэрэглэлийн системээр ангилан хөгжүүлж байгаа бөгөөд ӨМӨЗО-ы жуулчны “А” зэрэглэлийн зорих газрууд нь дараах хоёр үндсэн бүс нутагт төвлөрч байна. Үүнд:

- 1-р бүс нутаг: Бугат хот, Ордос хот, Баяннуур хотыг хамарсан Хөх хотын төв юм. Энэ хэсэгт хүн ам шигүү суурьшсан нь хотын аялал жуулчлалын үндсэн маршрутын төв болох бөгөөд Чингис хааны бунхан (5А), Жаожүн музей (4А), Улаанхугийн дурсгалын аялал жуулчлалын бүс (4А), Шяншаваны аялал жуулчлалын бүс (5А) зэрэг нь энэ бүс нутагт багтаж байна.
- 2-р бүс нутаг: Хөлөнбуйр орчмын бэлчээрийн нягтрал харьцангуй бага, байгалийн үзэсгэлэнт газар төвлөрсөн бөгөөд дэлхийн фашизмын эсрэг дайны Хайлаерын дурсгалын цэцэрлэгт хүрээлэн (4А), Хүхэ Нуэр жуулчны бүс (4А), Эргуна намгархаг газрын үзэсгэлэнт газар (4А), Хятадын Даур ардын зан үйлийн цэцэрлэгт хүрээлэн (4А) зэрэг нь энэ бүс нутагт багтана.

2004-2022 онд ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын газрууд тогтвортой өссөн нь тухайн орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлоготой нягт холбоотой бөгөөд ӨМӨЗО-ы аялал жуулчлалын нөөц, бүтээгдэхүүн төлөвлөлт, үйлчилгээний түвшин тасралтгүй дээшилж байгааг харуулж байна.


3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд нь Хөх хот, Бугат хот, Ордос хотын тойрог, Улаанцав хот, Ухай хот, Баяннуур хотод илүүтэй төвлөрч байна. Дачиншан Сафари цэцэрлэгт хүрээлэн (3А), Шилитужао (3А), Кубуки цөлийн аялал жуулчлалын бүс (3А) нь бүгд энэ бүсэд хамаарна (Зураг 2).



Зураг 2. ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тархалт


Одоогоор аялал жуулчлалын зорих газруудыг ангилах тодорхой нэгдсэн арга зүй байхгүй бөгөөд энэхүү судалгааны ажлын үр дүнд аялал жуулчлалын зорих газруудыг байгалийн ландшафт, соёлын ландшафт болон бусад төрлүүд хэмээн ангилах боломжтой. Байгалийн болон соёлын нөөцийн орон зайн тархалт, холбогдох мэдээллийг цуглуулан харьцуулсан шинжилгээ хийж үзвэл байгалийн ландшафт нь уул, гол мөрөн, нуур, геологи, биологийн төрөл зүйл, уур амьсгал зэрэг хүчин зүйлсээс, харин соёлын ландшафтын хувьд эртний туурь, хот барилга байгууламж, инженерчлэл, сонгодог цэцэрлэгт хүрээлэн, сүм хийд, шашин шүтлэгийн мөргөлийн газар, ардын зан заншил уламжлалт ахуй соёл, хоол ундааны соёл, ландшафтын гоо зүй, хот суурин газрын ландшафт зэргээс бүрдэж байхад бусад төрөлд хөдөө аж ахуйн экологийн парк, бизнес инкубатор парк, цанын бааз, шинжлэх ухаан, технологийн парк, үйлдвэрлэлийн газрууд бүрдүүлж байна.

Судалгаанд ӨМӨЗО-ы А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын газарзүйн тархалтаас үзвэл далайн түвшнээс дээш 1000-1500 м өндөрт орших газруудад хамгийн их тархалттай байв (Зураг 3).




Зураг 3. ӨМӨЗО-ы 3А-с дээш зэрэглэлийн аялал жуулчлалын газруудын тархалт


Аялал жуулчлалын зорих газрын нягтрал ба тархалт: ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын нягтрал ба тархалтыг Arcgis10.2 ашиглан гүйцэтгэхэд эдгээр газрууд нь ерөнхийдөө аймгийн төв хэсэгт төвлөрч байна. Хамгийн нягт тархалт нь ХӨ 40^0-42^0 , ЗУ 110^0-115^0 хооронд байна (Зураг 4-6).



Зураг 4. 2022 оны ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын нягтрал ба тархалт




Зураг 5. Өргөргийн тархалтын муруй нягтшил



Зураг 6. Уртрагийн тархалтын муруйн нягтшил


Аялал жуулчлалын зорих газруудын орон зайн өөрчлөлтийн шинжилгээ: Судлаач Кан (2018) Өмнөд Солонгосын Сөүл хотын аялал жуулчлалын газруудын орон зайн бүтцийг судлан “Зангуу цэгийн онол”-д тулгуурлан ГМС-ийн орон зайн автокорреляцийн хэсэгчилсэн индикатор (LISA)-оор аялал жуулчлалын төвлөрлийг тооцоолон нэг аялал жуулчлалын зорилтот газарт олон зангуу цэгүүд байж болохыг илрүүлсэн байдаг (Kang, 2018).

Өвөр Монголын 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудад 2004, 2010, 2016, 2022 онуудад орон зайн өөрчлөлтийн шинжилгээ хийхэд 2004 онд зорих газруудад бүтээн байгуулалт эхний шатандаа явж байсан бөгөөд нийт газар нутгийн хэмжээнд А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд маш цөөхөн, Ордос хотын баруун өмнөд хэсэгт төвлөрсөн байдалтай байв. 2010 он гэхэд аялал жуулчлалын салбарын хөгжлийг дагаад А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газар тасралтгүй өсөн нэмэгдэж Ордос хотын төв хэсэг, Хөх хотын төв хэсэг, Хайлаар хотод зэрэг 3 хэсэгт бөөгнөрөл үүссэн байна. 2016 он гэхэд аялал жуулчлалын зорих газар 5 хэсэг газарт төвлөрсөн байхад 2022 оны байдлаар бөөгнөрөл, тархалтын хүрээ хязгаарт өөрчлөлт орж Баяннуур хотын баруун өмнө хэсэгт байсан бөөгнөрөл баруун өмнө болон зүүн өмнө 2 хэсэгт хуваагдан улам бүр хүрээ нь томорсон байна (Зураг 7).



Зураг 7. Чухал ач холбогдолтой байдлын түвшин ба LISA бөөгнөрөл (2004-2022)


Аялал жуулчлалын зорих газруудын орон зайн хөдөлгөөний үйл явц: 2016 болон 2022 оны 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд ихэвчлэн Сөнөд зүүн хошуу, Сөнөд баруун хошуунд байрлах ба урт тэнхлэгийн радиуст өөрчлөлт эхлээд багасаж, дараа нь ихсэн, дахин багасах гэсэн зүй тогтолтой явагджээ. Богино тэнхлэгийн радиуст үндсэндээ мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй бөгөөд 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газар урт тэнхлэгийн чиглэлд тархсан байдалтай, эхлээд хоёр туйл руу тархан дараа нь сарниж, дахин хоёр туйл руу тархах явцтай байна. 2004-2022 онуудад 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын эллипс хэлбэр 5.12-оор аажмаар нэмэгдээр 2016 онд маш их өөрчлөгдсөн байна. 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын хөгжил анх Өвөр Монголын зүүн бүсэд үүсэж эхэлсэн ба 2004 болон 2010 онд үндсэндээ ижил тархан хөгжиж эхэлсэн дүр зураг ажиглагдаж байсан бол 2016 онд зүүн хэсэг, дунд хэсэгт 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрын тоо тасралтгүй өсөн нэмэгдэж, стандарт эллипс бүхэлдээ баруун урд зүг рүү шилжиж хувьсан өөрчлөгдсөн байна (Зураг 8).



Зураг 8. 3А зэрэглэлийн 2004, 2010, 2016, 2022 оны аялал жуулчлалын зорих газруудын эллипс тархалт

Аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтцийн өөрчлөлт: Судлаач Юэвэй, Синьян (2022) нар орон зайн вариограмм ашиглан Өвөр Монголын аялал жуулчлалын экологийн үр ашгийн орон зайн хувьслын загварыг судалж, газарзүйн жинлэсэн регресс (GWR) –ийн аргаар орон зайн хувьсалд нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэн Өвөр Монголын аялал жуулчлалаас олох үр ашиг харьцангуй багатай байгаа хэмээн дүгнээд аялал жуулчлалын зорих газрын орон зайн тархалтын хэлбэр, дотоод бүтцийн хувьсал нь тодорхой зүй тогтолтой, үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна хэмээн үзжээ (Yuewei, Xinyang, 2022).

ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд 2022 оны байдлаар, зам тээврийн үндсэн шугамын дагуу “цэгэн тэмдэглэгээ” орон зайн бүтэц бий болжээ. 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрын орон зайн өөрчлөлт Өвөр Монголын зүүн хэсэг, төв ба баруун хэсгүүдэд ялгаатай байгаа бөгөөд зүүн хэсгийн цэгэн тэмдэглэгээ нь орон зайн тархалтын өөрчлөлтийн чиг хандлагыг харуулж байна. Цэгэн тэмдэглэгээр үзүүлсэн орон зайн бүтцийн хөгжлийн зүй тогтлыг авч үзэхэд Өвөр Монголын зүүн бүс нутгийн зам харилцаа харьцангуй бага нягтралтай байгаа нь сүлжээ хэлбэрийн орон зайн бүтэц болон хөгжихөд хүндрэл үүсгэж байна. Тэнхлэгүүдийн харилцан огтлолцол нь тэнхлэг тус бүрийн өөр түвшний аялал жуулчлалын зорих газруудын хоорондын холбоог улам нэмэгдүүлэх бололцоотой. Нэг жуулчны зорих газар нөгөө газартайгаа холбогдож өөр шинэ аялал жуулчлалын зорих газрыг бий болгоно. Эндээс харахад 3А аялал жуулчлалын зорих газруудын орон зайн бүтэц нь “Цэгэн тэмдэглэгээ”-нээс аажмаар цаашид сүлжээ маягийн орон зайн бүтэц рүү шилжиж байна (Зураг 9).



Зураг 9. 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын зам тээврийн шугам дагуух тархалт (2004-2022)

Дүгнэлт

Энэ судалгаагаар ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын орон зайн мэдээллийн сангийн 2004, 2010, 2016, 2022 онуудын хугацааны өгөгдлийг сонгон авч тухайн газруудын орон зайн тархалтын ялгарлыг тодорхойллоо. ӨМӨЗО-ы аялал жуулчлалын зорих газрууд нь Хятад улсын аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн “Тогтвортой өсөлтийн үе (2004-2010)”, “Эрчимтэй өсөлтийн үе (2016-2022)” үеүүдэд эрчимтэй нэмэгдсэн ч аялал жуулчлалын зорих газрын дотоод бүтэц харилцан адилгүй байна. Судалгааны үр дүнгээр 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд орон зайн тархалтынхаа хувьд Өвөр Монголын зүүн хэсэг, төв хэсэг, баруун хэсгүүдэд илт ялгаатай байна.

ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын орон зайн тархалтанд эрчимтэй бөөгнөрөл явагдсан хэвээр байна. Бүс нутгийн хувьд 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын бөөгнөрлийн төв нь ЗУ $112^{\circ}-116^{\circ}$, ХӨ $41^{\circ}-44^{\circ}$ -д аажмаар баруун болон өмнө зүг рүү шилжиж байна. Замын чиглэл "урвуу V" хэлбэртэй байгаа бөгөөд бүх зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тархалтын хүндийн төв нь цаг хугацааны явцад төрөл бүрийн түвшинд шилжиж, жуулчдыг татахуйц түвшин доогуур байх тусам орон зайн жигд тархалттай байна.

Өвөр Монголын 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тээврийн төв зам дагуу тархсан тархалт нь голчлон өсөлтийн туйлын гол орон зайн бүтцээс “Цэгэн тэмдэглэгээ” орон зайн бүтэц рүү шилжсэнээр ихээхэн өөрчлөлтөнд орсон байна. Өвөр Монголын 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газрууд нь газар зүйн тархай байдлаас бөөгнөрсөн байдал рүү шилжиж байна.

ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудын тоо тасралтгүй нэмэгдсээр байгаа бөгөөд эдгээр газрууд нь ихэвчлэн тал газар, нуур цөөрөм, уул нурууд, түүх соёлын дурсгал зэрэг байгалийн өвөрмөц тогтоцтой газруудад үүсч байна. Аялал жуулчлалын зорих газруудын өнөөгийн байдал, оройн зайн өөрчлөлтийн зүй тогтолд тулгуурлан бүс нутгийн аялал жуулчлалын жишиг бүсийн бүтээн байгуулалт, стандартад нийцэж байгаа эсэхийг хэмжих, одоогийн зэрэглэлийг ахиулах боломжтой юм. Түүнчлэн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн онцлог, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээтэй уялдуулан нөөцийн давуу талыг ашиглан орон зайн бүтцийг оновчтой болгох, бодлогын дэмжлэгийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын маршрутыг сайжруулах, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх байдлаар ӨМӨЗО-ы 3А зэрэглэлийн аялал жуулчлалын зорих газруудыг тогтвортой, эмх цэгцтэй хөгжүүлэх улмаар аялал жуулчлалын брэндийг сурталчлах ажлыг өргөжүүлж, аялал жуулчлалын зах зээлийг хөгжүүлэх, аялал жуулчлалын эдийн засгийн хөгжлийг хурдасгах нөхцөл болж байна.

Ном зүй

1. Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал, (2024). <https://legalinfo.mn/>
2. Хишигдалай, У. (2015). монголын аялал жуулчлалын зорих газруудын өрсөлдөх чадварын эрэмбийн үнэлгээ. *ХАА-н шинжлэх ухаан сэтгүүл*, №14(01):235-241
3. Bihu, W., Ziyang, T. (2018). Analysis of the Spatial Structure of Tourist Attractions: A Case Study of the First Batch of National 4A Tourist Areas (Sites) in China. *Human Geography*, 1-5. <http://rwdl.xisu.edu.cn/EN/abstract/abstract8886.shtml> <https://doi.org/10.13959/j.issn.1003-2398.2003.01.001>
4. Brzezinska-Wojcik, T., Baranowska, M. (2012). The State of Development of Equestrian Tourism in the Lublin Region in the Context of Environmental Conditions. *Polish Journal of Sport & Tourism*, 256-262. <https://doi.org/10.2478/v10197-012-0025-y>
5. Cornelissen, S. (2005). Tourism impact, distribution and development: the spatial structure of tourism in the Western Cape province of South Africa. *Development Southern Africa*, 163-185. <https://doi.org/10.1080/03768350500163014>
6. GB/T 17775–1999. (1999). *Classification and Evaluation of Tourist Areas (Spots) Quality Grade*.
7. GB/T 17775-2003. (2003). *Standard of rating for quality tourist attractions*, China. <https://codeofchina.com/standard>
8. Gkoltsiou, A., Terkenli, T., & Koukoulas, S. (2013). Landscape indicators for the evaluation of tourist landscape structure. *International Journal of Sustainable Development & World Ecology*, 461-475. <https://doi.org/10.1080/13504509.2013.827594>
9. Haifeng, C., Wenhai, H. (2017). Spatial structure of A-level tourist attractions in Chizhou. *Geographical Science*, 1275-1280. <https://doi.org/10.13249/j.cnki.sgs.2014.010.1275>
10. He, W., et al., (2021). Spatial and Temporal Characteristics of Urban Tourism Travel by Taxi—A Case Study of Shenzhen, *International journal of Geo-Information*. Volume10, Issue 7, <https://doi.org/10.3390/ijgi10070445>
11. Hongqiao, W., Jiadong, Y., & Xiangjun, M. (2017). Spatial distribution characteristics and influencing factors of A-level tourist attractions in Northeast China. *Geographical Science*, 895-903. <https://doi.org/10.12062/cpre.20210436>

12. Hossain, M. K., Abdul Hamid, A. B., & Hanafiah, M. H. (2024). Tourism destination competitiveness and tourism performance in middle income countries. *Journal of Tourism, Hospitality and Culinary Arts*, 16(1), 781-801
<https://doi.org/10.1108/TR-05-2022-0258>
13. Huaguang, Y., Ruiyan, L. (2018). Spatial structure optimization of Zhangjiajie tourist attractions under the background of global tourism. *Journal of South-Central University for Nationalities (Humanities and Social Sciences)*, 74-78.
14. Jinghu, P., Junfeng, L. (2014). Spatial distribution characteristics and accessibility of A-level tourist attractions in China. *Journal of Natural Resources Science*, 55-66.
<https://doi.org/10.11849/zrzyxb.2014.01.006>
15. Kang, S., Lee, G., Kim, J., Park, D. (2018). Identifying the spatial structure of the tourist attraction system in South Korea using GIS and network analysis: An application of anchor-point theory, *Journal of Destination Marketing and Management*, Volume 9, 358-370.
<https://doi.org/10.1016/j.jdmm.2018.04.001>
16. Liu, C. (2017). Study on spatial structure dynamic evolution of tourism economic zone along Wuhan-Guangzhou HSR, *Open Access Library Journal*, 4, 1-11. DOI: [10.4236/oalib.1104045](https://doi.org/10.4236/oalib.1104045).
17. Lyu, J., Li, Y., Mao, Z., & Huang, H. (2023). The effect of innovation on tourists' revisit intention toward tourism destinations. *Tourism Review*, 78(1), 142-158.
18. Oppermann, M. (2014). Spatial Structure of Tourism in Peninsular Malaysia A Preliminary Study. *Tourism Recreation Research*, 54-59. <https://doi.org/10.1080/02508281.1992.11014641>
19. Qing, W., Xigui, L., & Li, W. (2017). Distribution pattern and spatial correlation analysis of A-level tourist attractions in Hunan Province. *Journal of Economic Geography*, 193-200.
20. Qiu, Y., Yin, J., Zhang, T., et al., (2021). Spatiotemporal Dynamic Analysis of A-Level Scenic Spots in Guizhou Province, China, *International journal of Geo-Information*. Volume10, Issue 8, <https://doi.org/10.3390/ijgi10080568>
21. Rasekhi, S., Hosseini, S. (2013). Spatial structure of tourism: an application of new economic geography in selected countries. *Tourismos*, 323-336. <https://doi.org/10.26215/tourismos.v8i2.371>
22. Wang, Y., Zhao, X. (2024). Study on the Spatial Distribution Characteristics and Influencing Factors of National Scenic Spots in China. *Science Research Publishing*, <https://doi.org/10.4236/oalib.1112680>
23. World Travel and Tourism Council. (2024), <https://wttc.org/>
24. Xiangyang, G., Qingzhong, M., & Xueqing, M. (2017). Spatial structure characteristics and temporal and spatial evolution of high-level tourist attractions in Yunnan Province. *Journal of Shaanxi Normal University (Natural Science Edition)*, 88-95
25. Xu, H., Shiqiao, F. (2020), Study on the Spatial Distribution and Influencing Factors of A-level Tourist Scenic Spots in Guangxi. *Guangxi Vocational Teachers College, Journal of Chinese Academy of Sciences*, 52-59.
26. Yuewei, W., Xinyang, W. (2022). The spatial pattern and influencing factors of tourism eco-efficiency in Inner Mongolia, China, *Frontiers Public Health*, Volume 10 – 2022. <https://doi.org/10.3389/fpubh.2022.1072959>
27. Zhang, T., Wang, Y., Wang, Y., Zhang, S., & Yu, H. (2022). Spatial structure and development of tourism resources based on point pattern analysis: A case study in Hainan Island. *Journal of Resources and Ecology*, 13(6), 1058-1073. <http://dx.doi.org/10.5814/j.issn.1674-764x.2022.06.011>
28. Zhao, M., Liu, J. (2021). Study on Spatial Structure Characteristics of the Tourism and Leisure Industry, *Journal of Sustainability*, 13(23), 13117; <https://doi.org/10.3390/su132313117>